



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан Орон нутгийн зам тээвэр ОНӨАТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2022/9/НА-СА-ОНА

Цахим хуудас:
peakomaudit@gmail.com
Дархан-Уул аймаг
2022 он

Тэргүүлэх аудиторын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч: **Ш.Мөнхбаяр**
Утас: **7037-3089**
Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn
Ахлах аудитор: **С.Батцэцэг**
Утас: **7037-3089**
Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn
Аудитор: **Б. Жаргалсайхан**
Утас: **9986-2066**
Цахим хаяг: peakomaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	12
4.1 Байгууллагын үйл ажилагаа	12
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	12
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	13
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
5.1 Шилэн дансны мэдээлэл	14
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
8. Аудитын илрүүлэлт	15
8.1 Залруулсан алдаа	15
8.2 Төлбөрийн акт	15
8.3 Албан шаардлага	15
8.4 Зөвлөмж	15
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчийн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

1.Аудитын санал дүгнэлт

ДАРХАН ОРОН НУТГИЙН
ЗАМ ТЭЭВЭР ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Ж.ДОРЖДЭРЭМ ТАНАА

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Тулга сувилал ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Тулга сувилал ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

АОУС 706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээллийг, харин бусад асуудлын хэсэгт аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудлыг оруулна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудал

Бусад асуудлын хэсэгт АОУС 706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүссэн тухай, санхүүгийн тайлангийн аудит, аудитын тайлантай холбоотой аудиторын хүлээх үүрэг хариуцлагын тухай дэлгэрэнгүй тайлбар өгөхөөр хууль тогтоомжоор шаардсан мэдээллийг тусгана.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

/Ш.МӨНХБАЯР/

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	35,677,581.78	32,883,533.68
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,875,513.13	11,375,110.47
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	9,875,513.13	11,375,110.47
31210	Төгрөг	9,875,513.13	11,375,110.47
31213	Арилжааны банк дахь харилцах	9,875,513.13	11,375,110.47
33	АВЛАГА	5,580,022.83	8,890,931.92
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	30,000.00	-
33401	Дансны авлага /ТӨҮГ/	5,550,022.83	8,890,931.92
35	БАРАА МАТЕРИАЛ	20,222,045.82	12,617,491.29
35400	Хангамжийн материал	20,222,045.82	12,617,491.29
35430	Сэлбэг хэрэгсэл	260,000.00	260,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,736,363.81	609,090.97
35450	Барилгын засварын материал	18,225,682.01	11,748,400.32
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	41,692,627,159.65	55,009,346,136.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	41,692,627,159.65	55,009,346,136.80
39200	Биет хөрөнгө	41,689,561,920.52	55,006,365,220.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,838,851.29	2,838,851.29
39202	Хуримтлагдсан элэгдэл	(232,689.20)	(276,823.85)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	32,800,000.00	32,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(26,693,333.36)	(28,293,333.38)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	131,588,350.00	134,960,804.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	(16,990,236.54)	(26,859,362.76)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,554,530.00	12,554,530.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,344,821.96)	(5,286,411.68)
39209	Зам, гүүрийн байгууламж	51,911,014,539.78	69,591,155,124.28
39210	Хуримтлагдсан элэгдэл	(10,352,973,269.49)	(14,707,228,158.25)
39300	Биет бус хөрөнгө	3,065,239.13	2,980,916.60
39303	Бусад биет бус хөрөнгө	3,168,300.00	3,168,300.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(103,060.87)	(187,383.40)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	41,728,304,741.43	55,042,229,670.48
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,086,556.74	2,643,097.70
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,086,556.74	2,643,097.70
41300	Өглөг	2,086,556.74	2,643,097.70
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	163,804.49	34,458.51
41360	Бусад өглөг	1,922,752.25	2,608,639.19
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	1,912,074.42	2,608,639.19
41364	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	10,677.83	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	41,726,218,184.69	55,039,586,572.78
51	Засгийн газрын хувь оролцоо	41,726,218,184.69	55,039,586,572.78
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	22,471,303,981.29	22,471,303,981.29
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	17,379,737,218.00	35,064,157,802.50
51200	Хуримтлагдсан үр дүн	(13,030,509,117.85)	(17,401,561,314.26)
51210	Өмнөх үеийн үр дүн	(9,601,246,377.03)	(13,029,325,274.39)
51220	Тайлант үеийн үр дүн	(3,429,262,740.82)	(4,372,236,039.87)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	14,905,686,103.25	14,905,686,103.25
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	41,728,304,741.43	55,042,229,670.48

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

			/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН	
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	309,021,633.18	393,154,451.36	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	309,021,633.18	393,154,451.36	
120	Нийтлэг татварын бус орлого	309,021,633.18	393,154,451.36	
120002	Хүүгийн орлого	115,580.11	-	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	308,906,053.07	392,894,376.36	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	308,906,053.07	392,894,376.36	
120009	Бусад орлого	-	260,075.00	
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,738,284,374.00	4,765,390,491.23	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,738,284,374.00	4,765,390,491.23	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,735,339,526.73	4,700,711,122.68	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	153,983,537.02	161,298,045.62	
210101	Үндсэн цалин	153,983,537.02	161,298,045.62	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,575,984.63	19,962,630.74	
210201	Тэтгэврийн даатгал	19,575,984.63	19,962,630.74	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,691,891.28	4,336,294.07	
210301	Гэрэл, цахилгаан	1,236,500.00	1,583,360.54	
210302	Түлш, халаалт	1,546,500.00	1,071,750.41	
210303	Цэвэр, бохир ус	125,664.00	328,910.40	
210304	Байрны түрээс	8,783,227.28	1,352,272.72	
2104	Хангамж, бараа материалын зардал	16,733,192.57	21,159,324.78	
210401	Бичиг хэрэг	1,723,950.00	1,713,908.68	
210402	Тээвэр, шатахуун	14,109,300.71	17,954,328.80	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	511,149.46	754,922.60	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	388,792.40	736,164.70	
2105	Нормативт зардал	1,652,000.00	1,718,000.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,652,000.00	1,718,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	68,621,249.30	115,613,665.86	
210604	Урсгал засвар	68,621,249.30	115,613,665.86	
2107	Томилолт, зочны зардал	116,000.00	283,000.00	
210702	Дотоод албан томилолт	116,000.00	283,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,242,531.02	3,567,926.97	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	125,600.00	41,958.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	50,000.00	
210807	Газрын төлбөр	-	11,096.00	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	141,358.02	172,645.35	
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,495,573.00	1,867,227.62	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,459,723,140.91	4,372,772,234.64	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,995,511.00	3,373,792.81	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,456,727,629.91	4,369,398,441.83	

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,944,847.27	64,679,368.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,298,847.27	8,229,154.55
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,298,847.27	8,229,154.55
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,646,000.00	56,450,214.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,646,000.00	56,450,214.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(3,429,262,740.82)	(4,372,236,039.87)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(3,429,262,740.82)	(4,372,236,039.87)

Пийк-Ом Аудит ХХК

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	34,837,020,004.29	14,905,686,103.25	(9,601,246,377.03)	40,141,459,730.51
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	34,837,020,004.29	14,905,686,103.25	(9,601,246,377.03)	40,141,459,730.51
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	5,014,021,195.00	-	-	5,014,021,195.00
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(3,429,262,740.82)	(3,429,262,740.82)
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	39,851,041,199.29	14,905,686,103.25	(13,030,509,117.85)	41,726,218,184.69
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	39,851,041,199.29	14,905,686,103.25	(13,030,509,117.85)	41,726,218,184.69
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	39,851,041,199.29	14,905,686,103.25	(13,030,509,117.85)	41,726,218,184.69
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	17,621,869,965.00	-	1,183,843.46	17,623,053,808.46
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(4,372,236,039.87)	(4,372,236,039.87)
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	57,472,911,164.29	14,905,686,103.25	(17,401,561,314.26)	54,977,035,953.28

Пийк-Ом Аудит ХХК

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	334,331,658.67	423,675,126.09
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	334,331,658.67	423,675,126.09
120	Нийтлэг татварын бус орлого	334,331,658.67	423,675,126.09
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	334,331,658.67	423,675,126.09
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	334,331,658.67	423,675,126.09
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	324,700,658.79	422,175,528.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	324,700,658.79	422,175,528.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	323,054,658.79	422,175,528.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	117,095,519.33	132,631,947.91
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	117,095,519.33	132,631,947.91
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,938,011.28	38,418,070.86
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	36,938,011.28	38,418,070.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,974,317.19	49,237,253.36
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	19,974,317.19	49,237,253.36
2104	Хангамж, бараа материалын зардал	108,231,582.87	153,977,456.26
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	108,231,582.87	153,977,456.26
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,815,228.12	47,910,800.36
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	40,673,870.10	47,738,155.01
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	141,358.02	172,645.35
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,646,000.00	0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,646,000.00	0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,646,000.00	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	9,630,999.88	1,499,597.34
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	115,580.11	0
140007	Хүлээн авсан хүүний орлого	115,580.11	0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	115,580.11	0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.02	0
14	Бусад эх үүсвэр	10,954,307.00	0
145007	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	10,954,307.00	0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	10,954,306.98	0
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөр төлсөн мөнгө	10,954,306.98	0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	9,746,580.01	1,499,597.34
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	128,933.12	9,875,513.13
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,875,513.13	11,375,110.47

Пийк-Ом Аудит ХХК

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт	м/төг	309,021.60	424,712.00	393,154.40	(31,557.60)	92.57
	<i>Шалган бүртгэх товчооны орлого</i>	м/төг	81,489.10	100,000.00	92,740.90	(7,259.10)	92.74
	<i>1 удаагийн хураамжийн орлого</i>	м/төг	183,668.80	260,000.00	234,936.90	(25,063.10)	90.36
	<i>Хүнд даацын авто машинд олгох зөвшөөрөл</i>	м/төг	7,622.70	9,000.00	13,372.70	4,372.70	148.59
	<i>Тээрийн хяналтын орлого</i>	м/төг	6,902.70	4,080.00	6,683.60	2,603.60	163.81
	<i>Гэрээт ажлын орлого</i>	м/төг	29,222.70	51,632.00	45,160.20	(6,471.80)	87.47
	<i>Хүүгийн орлого</i>	м/төг	115.60	-	260.10	260.10	
2	Нийт орлого	м/төг	309,021.60	424,712.00	393,154.40	(31,557.60)	92.57
3	Нийт зардал	м/төг	3,738,287.70	405,340.40	4,765,390.50	4,360,050.10	1,175.65
	Үүнээс: Удирдлагын зардал	м/төг	3,738,287.70	405,340.40	4,765,390.50	4,360,050.10	1,175.65
4	Татварын өмнөх ашиг	м/төг	(3,429,266.10)	19,371.60	(4,372,236.10)	(4,391,607.70)	(22,570.34)
5	Цэвэр ашиг /алдагдал /	м/төг	(3,429,266.10)	19,371.60	(4,372,236.10)	(4,391,607.70)	(22,570.34)
6	Төсвийн төлбөр	м/төг	77,695.80	38,610.80	87,450.70	48,839.90	
	а/НӨАТ	м/төг	31,219.10	38,610.80	38,597.90	(12.90)	
	б/НДШ	м/төг	36,938.00	-	38,418.10	38,418.10	
	в/ХАОАТ	м/төг	9,454.70	-	10,350.70	10,350.70	
	г/АТБӨЯХАТ	м/төг	84.00	-	84.00	84.00	
7	Нийт ажиллагсдын тоо	Хүн	22.00	22.00	17.00	(5.00)	77.27
8	Нийт цалингийн сан	м/төг	153,983.50	175,474.00	157,617.70	(17,856.30)	89.82
9	Нэг ажиллагчийн дундаж цалин	м/төг	6,999.25	7,976.09	9,271.63	3,571.26	116.24
10	Борлуулалтын орлогын 1 төг ногдох зардал	м/төг	12.10	0.95	12.12	(138.16)	1,270.02
11	Хөрөнгө оруулалт	м/төг	-	-	5,014,021.20	5,014,021.20	
12	Нийт авлага	м/төг	5,580.00	-	5,580.02	5,580.02	
13	Нийт өглөг	м/төг	2,086.60	-	2,086.55	2,086.55	
	Богино хугацаат өглөг	м/төг	2,086.60	-	2,086.55	2,086.55	

Пийк-Ом Аудит ХХК

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дархан орон нутгийн зам тээвэр ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд тус газрын дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад мөнгөн кассын зарцуулалттай холбоотой өгсөн зөвлөмж тусгасан болно.

Аудитыг 2022 оны 2 дугаар сарын 10-наас 2022 оны 3 дугаар сарын 15-ны хооронд Пийк Ом Аудит ХХК-ийн аудитор Б.Жаргалсайхан, аудитор А.Батболд нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Б.Наранчимэг хэрэгжүүлсэн.

Дархан орон нутгийн зам тээвэр ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Пийк-Ом Аудит ХХК-д 2022 оны 2 дугаар сарын 01-ны өдрийн 11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Дархан орон нутгийн зам тээвэр ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны орлогын

дэлгэрэнгүй тайлангын орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангын орлого 303,937.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 4,559.1 мянган төгрөгөөр гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 буюу 3,419.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Дархан орон нутгийн зам тээвэр ОНӨААТҮГ нь “Авто зам ашиглалтын аюулгүй байдлыг ханган орон нутгийн зорчигч тээврийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, зам замын байгууламжийг хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн аюулгүй, ая тухтай үйлчилгээ хүргэх нөхцөлийг бий болгоход чиглэнэ” гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дархан орон нутгийн зам тээвэр ОНӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Орон нутгийн авто замын санг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах
- Орон нутгийн авто зам, замын байгууламжийн ашиглалтанд хяналт тавьж, арчлалт хамгаалалт хийх
- Орон нутгийн чанартай авто замын засвар, арчлалтын ажлыг гүйцэтгэж, байнгын бэлэн байдлыг хангах
- Авто зам, замын байгууламжийн хувийн хэрэг, паспортод баяжилт хийх

Тус байгууллага нь “орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар” гэсэн статустай бөгөөд 100 хувь орон нутгийн өмчид харьяалагдаж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Дархан орон нутгийн зам тээвэр нь Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 94-р тогтоолоор байгуулагдсан орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар юм.

Дархан орон нутгийн зам тээврийн удирдлагыг Дархан-Уул аймгийн Засаг дарга томилсон байна.

Тус газар нь 2021 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөндөө 14 үндсэн зорилт дэвшүүлсэн ажилласан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны хэрэгжүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”

- ЗГ-ын 2021 оны 124 тоот тогтоол “ТБОНӨБАУ худалдан авах босго үнэ шинэчлэн тогтоох тухай”

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Дархан орон нутгийн зам тээвэр ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	9,875.5	11,375.1	1,499.6
Авлага	5,580.0	8,890.9	3,310.9
Бараа материал	20,222.1	12,617.5	(7,604.6)
Үндсэн хөрөнгө	41,692,627.1	55,009,346.1	13,316,719.0
Нийт хөрөнгө	41,728,304.7	55,042,229.6	13,313,924.9
Өр төлбөр	2,086.5	2,643.0	556.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	41,726,218.2	55,039,586.6	13,313,368.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	41,728,304.7	55,042,229.6	13,313,924.9

Банк дахь мөнгөний үлдэгдэлд 11,375.1 мянган төгрөг болж 1,499.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Авлагын үлдэгдэлд 8,890.9 мянган төгрөг болж өссөн нь шалган бүртгэх товчооны орлого болох 350.9 мянган төгрөг, Ус суваг ХК-иас 7,340.0 мянга, Элит хөгжил ХХК-иас 1,200.0 мянган төгрөгийн гэрээт ажлын орлого тайлант онд ороогүйгээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 12,617.5 мянган төгрөг болж 7,604.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 130,819.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 138,424.0 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулснаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны хувьд тайлант онд 3,372.4 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч Дархан–Уул аймгийн Иргэдийн төлөөлөгчдын хурлын 2021 оны 39 тоот тогтоолоор 12,607,252.4 мянган төгрөгийн авто зам, гүүрний засвар, Дархан-Уул аймгийн Иргэдийн төлөөлөгчдын хурлын 2021 оны 58 тоот тогтоолоор 606,500.0 мянган төгрөгийн авто замын засвар, Дархан орон нутгийн зам тээвэр ОНӨААТҮГ-ын даргын 2022 оны 10 тоот албан бичгээр 4,408,117.6 мянган төгрөгийн авто зам, авто зогсоол, замын тэмдэг нийт 17,684,420.6 мянган төгрөгийн хөрөнгийн газрын сайжруулалт дансанд үнэ төлбөргүй орлогоор бүртгэн, 4,280.0 мянган төгрөгийн цаашид ашиглах боломжгүй болсон Шарын голын Аргалын гармын гүүрийг Дархан-Уул аймгийн засаг даргын 2021 оны 12 сарын 31-ны өдрийн 01-01А/398 тоот захирамжаар акталж, 4,356,859.3 мянган төгрөгийн элэгдэл байгуулан, үндсэн хөрөнгө актлахтай холбоотой хуримтлагдсан элэгдэл дансыг 2,604.4 мянган төгрөгөөр залруулга бичилт хийн оны эцэст 69,711,758.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 55,039,586.6 мянган төгрөг болж 13,313.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Дархан орон нутгийн зам тээвэр ОНӨААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Дархан орон нутгийн зам тээвэр ОНӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, худалдан авах ажиллаганы төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 424,712.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 405,340.4 мянган төгрөгөөр, ашгийг 19,371.6 мянган төгрөгөөр тогтоосон байна.

Нийт орлогын гүйцэтгэл 393,154.4 мянган төгрөг болж төлөвлөгөөнөөс 31,557.6 мянган төгрөг буюу 7.4 хувиар дутуу биелсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 4,765,390.5 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 4,360,050.1 мянган төгрөг буюу 1,175,6 хувиар зардал өссөн нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал өндөр байгуулснаас нөлөөлсөн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 4,372,236.0 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 4,352.864.4 мянган төгрөгөөр хэтэрсэн нь, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг тайлант оны төлөвлөгөөнд тусгаагүйгээс шалтгаалсан байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дархан орон нутгийн өмчийн газар нь тайлант онд нийт 146 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4,966.5 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 368.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгснийг 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		/мянган төгрөг/ Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага	1	4,466.5	1	4,466.5			100
Зөвлөмж	3	368.8	3	368.8			100
Нийт дүн	4	4,835.3	4	4,835.3			100

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт **3,302.0** мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3,302.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

8.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулсан алдаа гараагүй болно

8.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

8.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөх зөрчилтэй асуудал гараагүй болно.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Байгууллагын 2021 оны цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардлаас Аймгийн Засаг даргын 2021 оны 01-А/200 дугаар захирамжаар байгууллагын дарга Ж.Дорждэрэмд 1 сарын үндсэн цалинтай тэнцэх 896.0 мянган төгрөгийн мөнгөн шагналыг зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 онд баталсан “Эдийн засгийн ангилал батлах тухай” 5 дугаар тушаалын “Цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардлын ангилалд ажиллагсдын цалин, хөлс болон хуулиар нийгмийн даатгалын шимтгэл бодогдох нэмэгдэл урамшлын зардлууд хамаарна ...” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалыг мөрдөж, 2022 онд батлагдсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардлаас мөнгөн шагналд хөрөнгө зарцуулахгүй байх.

2. Мөнгөн кассын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант онд бэлэн мөнгөн зарлага гаргахдаа кассын үйл ажиллагааны журмыг боловсруулж мөрдөөгүй 2,406.0 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна. Энэ нь Дархан Орон нутгийн зам тээврийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтын 4.1.2-д

мөнгөн хөрөнгийн бүртгэлийн үйл ажиллагаанд Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагад мөрдөгдөх кассын ажиллагааны журам”-ыг мөрдөнө, 4.1.2-Б –д “төсөвт байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба төлбөрийн нийт дүн нь 300.0 мянган төгрөгөөс хэтрэхгүй байна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Кассын үйл ажиллагааны журмыг боловсруулж мөрдөн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхий

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дархан Орон нутгийн зам тээвэр ОНӨААТҮГ	2	3,302.0							2	3,302.0
	Дүн	2	3,302.0							2	3,302.0

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/